

5

БҮРТГЭЛИЙН БОДЛОГО, ХӨГЖЛИЙН ЧИГ ХАНДЛАГА

Р. Буянжаргал, Н.Ганбаатар

Зах зээлийн эдийн засгийн харилцаанд шилжсэнээр аж ахуйн нэгж байгууллагын нягтлан бодох бүртгэлийг олон улсын жишигт ойртуулах, ижилтгэх бүртгэлийн арга горимуудыг боловсронгуй болгох, эрх зүйн орчинг бүрдүүлэх талаар багагүй зүйл хийж байна. 1993 онд Нягтлан Бодох Бүртгэлийн тухай хууль, 1997 онд Аудитын тухай хууль батлагдсан нь бүртгэл аудитын үйл ажиллагааг хуулийн хэм хэмжээнд явуулах боломж бүрдсэн. Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт, Аудитын олон улсын стандартыг орчуулж хэвлүүлсэн нь бүртгэл, аудитын үйл ажиллагааг олон улсын жишигт ойртуулан, нягтлан бодогч аудиторудыг гарын авлага, арга зүйгээр хангах нөхцөл бүрджээ. Энэ бүртгэлийн хууль, стандартад үндэслэн аж ахуйн байгууллагууд бүртгэлийнхээ бодлогыг тодорхойлдог.

Төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгийн бодлого зонхилж байгаа үед бүртгэлийн бодлогоо тодорхойлох эрхгүй хатуу тогтсон дүрэм, журам, аргачилалын дагуу нягтлан бодох бүртгэлийг хөтөлдөг байсан. Байгууллагууд өөрсдөө бүртгэлийн бодлогоо тодорхойлохын тулд бүртгэлийн бодлого гэж юу болох, түүнийг хэрхэн боловсруулах шаардлага гарлаа. Энэ удаа бүртгэлийн бодлого гэж юу болох түүнд ямар шаардлагууд тавигддаг, түүнийг хэрхэн төлөвлөж хэрэгжүүлэх, өөрчлөх боломжтойг авч үзье.

Нягтлан бодох бүртгэлийн бодлого нь санхүүгийн тайланг бэлтгэх, танилцуулах үед байгууллагын удирдлагын сонгон авдаг бүртгэлийн зарчим, арга, горимуудаас бүрдэнэ. Энэ бүхэн тухайн байгууллагад мөрддөг дүрэм, журамд тусгагдана. Байгууллагын удирдлага нь мөрдөгдөж байгаа бүртгэлийн бодлого, практикт хэр зэрэг нийцэж байгаад тухай бүрд үнэлэлт, дүгнэлт өгч байдаг. Мөн бүртгэлийн бодлогыг тогтвортой байлгаж улам боловсронгуй болгох үүрэг хүлээдэг. Өргөн утгаар нь авч үзвэл: бүртгэлийн бодлогууд нь дараах зорилтуудыг хэрэгжүүлэх замаар нягтлан бодох бүртгэлийг цаг тухайд нь үнэн зөв хөтлөхөд бүрэн чиглэгдэнэ. Үүнд:

1. Аж ахуйгаа оновчтой, үндэслэлтэй зөв удирдах төлөвлөх шийдвэр гаргахад байнга дэмжлэг үзүүлэх
2. Мэдээлэл хэрэглэгчдэд баталгаатай мэдээллээр үйлчлэх
3. Татвараа зөв ноогдуулах, түүний хүрээг өргөтгөх зорилгоор бүртгэлийн бодлогоо боловсруулж хатуу мөрдөхөд чиглэдэг байна.

Харин нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогын үүргийг нарийвчлан авч үзвэл:

1. Татвар ноогдуулалт, санхүүгийн болон удирдлагын бүртгэлийн хооронд зохистой тэнцвэрт харьцааг бий болгох
2. Байгууллагаа оновчтой удирдахад шаардлагатай үнэн зөв мэдээллээр бүрэн хангахад чиглэгдэнэ.

Санхүүгийн баталгаатай мэдээлэлд дараах шаардлагууд тавигддаг энэ нь бүртгэлийн бодлогын чиг хандлагыг тогтооход зайлшгүй харгалзаж үзэх чухал хүчин зүйл болдог. Санхүүгийн баталгаат мэдээлэлд:

1. Мэдээлэл хэрэглэгчдийг оновчтой зөв шийдвэр гаргахад хэрэгтэй, хангалттай, ач холбогдолтой байх
2. Мэдээлэл нь найдвартай, баталгаатай, үнэн зөв байх
3. Мэдээлэл нь ойлгомжтой, оновчтой, авсаархан, үнэнд нийцсэн байх
4. Олон жилийн үзүүлэлтүүд, ижил төрлийн аж ахуйн нэгжүүдийн үндсэн үзүүлэлтүүдийг зэрэгцүүлэн үнэлэлт, дүгнэлт хийх зэрэг асуудлууд тусгагдсан байх ёстой.

Аж ахуйн нэгж байгууллага нягтлан бодох бүртгэлийн бодлогын хөгжлийн чиг хандлагаа боловсруулахдаа дор дурьдсан нягтлан бодох бүртгэлийн гол зарчмуудыг үндэс болгон заавал хэрэгжүүлнэ. Үүнд:

1. Аж ахуйн үйл ажиллагаа тогтвортой, тасралтгүй явагдах нөхцөл боломж хангагдсан байх
2. Бүртгэлийн бодлогын чиг хандлага тодорхой хугацаанд тогтвортой байх
3. Нягтлан бодох бүртгэлийг бэлтгэх, хөтлөх, тайлагнахдаа бүртгэлийн аккруэль зарчмыг тууштай баримтлах шаардлагатай байдаг.

Бүртгэлийн бодлогыг дараах түвшинд хэрэгжүүлж байх ёстой. Үүнд:

1. Олон улсын түвшинд
2. Улс орны түвшинд
3. Салбарын түвшинд
4. Аж ахуйн нэгж байгууллагын түвшинд

Бүртгэлийн бодлогын хөгжлийн чиг хандлагыг тодорхойлоход дараах үндсэн шаардлагууд тавигдана. Үүнд:

1. **Иж бүрэн байх.** Нягтлан бодох бүртгэлд аж ахуйн үйл ажиллагаанд гарсан бүх гүйлгээ бүрэн гүйцэд тусгагдсан байна. Бүртгэлд тусгагдаагүй хөрөнгө, орлого, зардал, өр авлага байж болохгүй.
2. **Хянамгай байх.** Санхүүгийн тайланг бэлтгэж гаргахдаа хянуур, нягт нямбай байхын зэрэгцээгээр, мэдээллийг орхигдуулах, будлиантуулах, хөрөнгө, орлого, үр дүнг нууж дарагдуулах зэрэг зохисгүй дутагдал зөрчил гаргаж огт болохгүй.
3. **Хэлбэрээс агуулгад илүү анхаарах.** Санхүүгийн мэдээллийг судалж боловсруулахдаа тогтсон хэв загварт баригдалгүй түүний агуулга, мөн чанарыг гүнзгийрүүлэн мэдэх замаар оновчтой сонголт хийдэг байх. Мөн олон улсын түвшинд санхүүгийн мэдээлэл хэр шинэчлэгдэн өөрчлөгдөж байгааг мэдэрч ажиллах шаардлагатай байна.
4. **Зөрчилгүй байх.** Санхүүгийн тайланд тусгагдсан үзүүлэлтүүд нь хураангуйлсан бүртгэл болон анхан шатны бүртгэлийн дүнтэй тохирч байхын зэрэгцээгээр анхан шатны баримт дахь мэдээлэл батлагдаж нотлогдсон байвал зохино.

5. Оновчтой байх. Нягтлан бодох бүртгэлийн бүтэц, зохион байгуулалт оновчтой авсаархан хөдөлмөр зарцуулалт багатай, хэмнэлттэй байх.

Бүртгэлийн бодлогын, хөгжлийн чиг хандлагыг тодорхойлохдоо дараах аргуудыг хослуулан хэрэглэвэл зохимжтой. Үүнд:

1. Нягтлан бодох бүртгэлд хэрэглэх маягт, аргачлалыг сонгох, оновчтой боловсруулах
2. Дансны төлөвлөгөөг хэрэгцээ шаардлага хангахаар бүрэн боловсруулж батлуулах, дагаж мөрдөх
3. Үндсэн хөрөнгийн өртгийг зах зээлийн нөхцөлтэй уялдуулан үнэлж бүртгэх, оновчтой тогтоох
4. Биет бус хөрөнгийн өртгийг стандартын дагуу үнэлж бүртгэх, тайлан тэнцэлд бүрэн тусгах, элэгдлийг зөв тооцон зардалд тусгах
5. Материалын өртгийг жишиж харьцуулж тодорхойлох, түүний зарцуулалтыг оновчтой тодорхойлох
6. Нөөц санг зөв бүрдүүлэх, зориулалтын дагуу зарцуулах, түүний биелэлтийг хатуу хянах
7. Үйлдвэрлэлийн зардлыг бүртгэх аргаа зөв тогтоох, энэ үндсэн дээр бүтээгдэхүүний өртгийг зөв тодорхойлж хэрэгжилтэнд хяналт тавих
8. Үндсэн хөрөнгийн элэгдлийг хэрхэн тооцох аргаа оновчтой сонгож, тогтвортой мөрдөх
9. Валютын ханшны өөрчлөлтийг цаг хугацаанд нь үнэн зөв бүртгэлд тусгаж өгөх

Нягтлан бодох бүртгэлийн бодлогыг хэрэгжүүлэхдээ юу анхаарах вэ гэвэл:

1. Хүлээн зөвшөөрсөн олон аргуудаас өөрийн байгууллагын үйл ажиллагаанд хэрэгжиж үр ашгаа өгөх аргаа сонгох
2. Өмчийн хэлбэр аж ахуйн хэмжээнээс үл хамааран бүртгэлийн бодлого түүний хөгжлийн чиг хандлагыг товлон тогтоох, боловсронгуй болгох хэтийн төлөвийг тогтоох бодлогоо байгууллагын удирдлага хариуцан сонгох
3. Бүртгэлийн бодлого нь төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэр, захирлын тушаал зэрэг захирамжаар хүчин төгөлдөр болж батлагдан мөрдөгддөг байх ёстой.

Аж ахуйн бүртгэлийн бодлого түүний хөгжлийн чиг хандлага дараах хүчин зүйлээс болж өөрчлөгддөг. Үүнд:

1. Эдийн засаг, хууль эрх зүйн орчин өөрчлөгдөх үед
2. Нягтлан бодох бүртгэлийн олон улсын болон үндэсний стандарт, дүрэм, журамд өөрчлөлт гарсан үед
3. Аж ахуйн нэгж байгууллагын өмчлөгч нь өөрчлөгдөх үед
4. Аж ахуйн нэгжүүд нэгдэх, салах үед бүртгэлийн зохион байгуулалт, түүний бодлогод өөрчлөлт гарахад.

Аж ахуйн нэгж байгууллагууд нь бүртгэлийн бодлогод өөрчлөлт орсон бол түүнийгээ тайлан тэнцлийн нэмэлт тодруулгадаа заавал тайлбар хийх ёстой. Энэхүү нэмэлт тодруулгад баримталж байгаа бүртгэлийн ерөнхий бодлого, түүнд гарсан өөрчлөлт тухайлбал: хөрөнгө нөөцийн үнэлгээ, материал бүтээгдэхүүний өртөг, үндсэн хөрөнгийн элэгдлийг хэрхэн тооцох, ашиг алдагдлаа хэрхэн тодорхойлоход ямар арга хэрэглэх болсон түүний эдийн засгийн үр өгөөж, бүртгэлийн бодлогын хөгжлийн хэтийн төлөв байдлын талаар тусгасан байна.